

**“ТАВ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

№ 26/2/47

Улаанбаатар хот

**ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ЭРХ ОЛГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6.3.5 дахь заалт, ТАВ (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТАВ (ХК) компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулах төслийг 2026 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн дотор боловсруулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
2. Төсөл боловсруулахад шаардлагатай мэдээлэл, баримтыг саадгүй гаргаж өгөхийг Гүйцэтгэх захирал Р.Доржмядаг-д даалгасугай.
3. Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй, хороонд бүртгэлтэй хуулийн этгээдүүдээс сонгон ТАВ (ХК) компанийн сүүлийн 6 сарын хугацааны хувьцаа эзэмшигчдэд ногдох нэгж хувьцааны үнэлгээг тогтоолгох, тайлан дүгнэлт гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Ганбол-д үүрэг болгосугай.
4. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй, хороонд бүртгэлтэй сонгогдсон хуулийн этгээдтэй гэрээний нөхцөлийг тохирч, гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал /Р.Доржмядаг/-д олгосугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА

С.ГАНБОЛД

**“ТАВ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 06 дугаар  
сарын 19-ний өдөр

№. 26/2/520

Улаанбаатар хот

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТОМИЛОХ ТУХАЙ**

Компанийн тухайн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, 83 дугаар зүйлийн 83.15, 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.9, 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, ТАВ (ХК)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “ТАВ” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлаар Рагчаабазар овогтой Доржмядаг РД(УХ 91122716)-ыг 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн томилсугай.
2. Энэхүү тогтоолын 1-т заасан Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлыг хүлээлцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (С.Ганболд)-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын 1-т заасан гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, энэхүү ажиллагаатай холбогдсон маягт бөглөх, материал хүлээлгэж өгөх, хүлээн авах, гарын үсэг зурах болон шаардлагатай бусад эрхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Б.Пүрэвсүрэн)-т даалгасугай.
4. Энэхүү тогтоолын 1-т заасан гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж болон холбогдох байгууллагад бүртгүүлэх, энэхүү ажиллагаатай холбогдсон материал хүлээлгэн өгөх, холбогдох бусад эрхийг ТУЗ-ийн нарийн бичгийн (Б.Пүрэвсүрэн)-т даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “ТАВ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (С.Ганболд)-т үүрэг болгосугай.



**С.ГАНБОЛД**